

**ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН АРИЛЖААНЫ ЗУУЧЛАГЧ /БРОКЕР/-ДЫН  
2013 ОНЫ 2 ДУГААР УЛИРАЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2013.11.11

Улаанбаатар хот

**НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР**

Санхүүгийн зохицуулах хорооны /цаашид Хороо гэх/ 2013 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам” батлагдснаар хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч буюу брокер /ХААБ/-уудад тусгай зөвшөөрөл олгох эрх зүйн үндэс бий болсон.

Одоогийн байдлаар Хорооноос нийт 33 ХААБ-д Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноос ямааны ноолуурын арилжааны зуучлал эрхлэх 33, хонины ноосны арилжааны зуучлалын үйл ажиллагаа давхар эрхлэх зөвшөөрөлтэй 29 ХААБ байна. Үүнээс 29 ХААБ Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцох суудлын эрх авсан байна.

Хорооны 2013 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит хуралдаанаас хойшхи хугацаанд ХААБ-д зөвшөөрөл олгож байгаа ба Хорооны зүгээс 2013 оны 2 дугаар улирлаас эхлэн ХААБ-уудын санхүүгийн тайланг хүлээн авч нэгтгэх ажлыг хийж байна.

Иймд ХААБ-уудын санхүүгийн тайлангийн өмнөх үеийн статистик мэдээлэл байхгүй, харьцуулсан үзүүлэлтүүд тайлант улирлын хувьд гарахгүй онцлогтой болно.

Мөн ХААБ-уудын хувьд шинэ тутам зохицуулалтанд орж байгаа ба санхүүгийн тайланг бүрэн гүйцэд, алдаагүй, хугацаанд гарган ирүүлж хэвшээгүй зүйл ажиглагдаж байна.

Тухайлбал: Тайлан ирүүлбэл зохих 33 ХААБ-уудаас 25 нь тайланг ирүүлсэн, зарим ХААБ-ын балансын дүн зөрүүтэй, балансын тайлант үеийн ашиг/алдагдалын дүн, орлого үр дүнгийн тайлангийн ашиг/алдагдалын дүн зөрүүтэй, хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг тайланд тусгаагүй гэх мэт зөрчил, дутагдалуудтай байна.

Тайлант хугацаанд ХААБ-ийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон, салбар нэгж байгуулсан тохиолдол байхгүй байна.

ХААБ-уудийг үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн байршилаар нь ангилвал:

№	Аймаг/ хот	Тоо	Хувь
1	Улаанбаатар	17	52%
2	Баян-Өлгий	2	6%
3	Завхан	2	6%
4	Баянхонгор	1	3%
5	Дорнод	1	3%
6	Төв	1	3%
7	Увс	1	3%
8	Хэнтий	1	3%
9	Говь-Алтай	1	3%
10	Дархан-Уул	1	3%
11	Дундговь	1	3%
12	Өвөрхангай	1	3%

13	Өмнө-Говь	1	3%
14	Ховд	1	3%
15	Хөвсгөл	1	3%
Нийт		33	100%

2013 оны 2 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй 33 ХААБ-ын 52 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн нь 14 аймагт үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнийг газар зүйн байршилаар нь харуулбал:



## ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### 2.1. Ерөнхий санхүүгийн үзүүлэлтүүд

/Төгрөгөөр/

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлант хугацаанд
1	Нийт ХААБ	33
2	Тайлан иүүрлсэн ХААБ	25
3	Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо	144
4	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,068,933,063.46
5	Эргэлтийн бус хөрөнгө	383,672,732.31
6	<b>Нийт актив</b>	<b>5,452,605,795.77</b>
7	Өр төлбөр	574,552,427.85
8	Эзэмшигчдийн өмч	4,877,785,096.92
9	<b>Нийт пассив</b>	<b>5,452,605,795.77</b>
10	Нийт орлого	6,511,861,923.40
11	Нийт зардал	6,240,458,835.92
12	<b>Нийт ашиг</b>	<b>271,403,087.48</b>

### 2.2 Активын бүтэц

ХААБ-уудын активын бүтэц 2013 оны 2 дугаар улирлын байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

/Төгрөгөөр/

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	Дүн	Хувь
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,317,585,118.72	60.8%
1.1.2	Дансны авлага	1,079,663,634.74	19.8%
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	432,008,810.00	7.9%
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	1,728,200.00	0.03%
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/гооцоо	200,000,000.00	3.7%
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	37,947,300.00	0.7%
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
<b>1.1.10</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>5,068,933,063.46</b>	<b>93.0%</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	170,281,875.68	3.1%
1.2.2	Биет бус хөрөнгө	649,156.63	0.01%
1.2.3	Бусад эргэлтийн бус хөрөнгө	212,741,700.00	3.9%
<b>1.2.4</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>383,672,732.31</b>	<b>7.0%</b>
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,452,605,795.77</b>	<b>100.0%</b>

ХААБ-уудын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн активын үзүүлэлтээс харахад эргэлтийн хөрөнгө нийт активын 93.0 хувь, эргэлтийн бус хөрөнгө 3.9 хувийг тус тус эзэлж байна. Энэ харьцаа ХААБ нь санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа явуулдаг байгууллагын хувьд байвал зохих харьцаанд нийцсэн үзэж болохоор байна.

### 2.3 Пассивын бүтэц

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	Дүн	Хувь
2.1.1	Дансны өглөг	21,877,593.74	0.4%
2.1.2	Цалингийн өглөг	386,000.00	0.01%
2.1.3	Татварын өр	37,783,656.41	0.7%
2.1.4	НДШ-ийн өглөг	1,783,178.00	0.03%
2.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.6	Урьдчилж орсон орлого	11,029,000.00	0.2%
2.1.8	Бусад богино хугацаат өр төлбөр	1,693,000.00	0.0%
<b>2.1.9</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>74,552,428.15</b>	<b>1.4%</b>
2.2.1	Ур хугацаат зээл	500,000,000.00	9.2%
<b>2.2.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>500,000,000.00</b>	<b>9.2%</b>
<b>2.3</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>574,552,428.15</b>	<b>10.5%</b>
2.4.1	Өмч: - төрийн	-	-
2.4.2	- хувийн	4,522,690,731.00	82.9%
2.4.3	- хувьцаат	541,110.00	0.0%
2.4.4	Эздийн өмчийн бусад хэсэг	73,015,000.00	1.3%
2.4.5	Хуримтлагдсан ашиг	5,405,800.00	0.1%
2.4.6	тайлант үеийн	281,538,255.62	5.2%
2.4.7	өмнөх үеийн	-	-
<b>2.4.8</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>4,877,785,096.62</b>	<b>89.5%</b>
	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,452,605,795.77</b>	<b>100.0%</b>

Тайлант улиралд нэгтгэлд хамрагдсан ХААБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 4,522,690,731.00 төгрөг буюу нийт пассивын 82.9 хувийг эзэлж байна. Хорооны

зүгээс ХААБ-уудын мөнгөн хөрөнгөөр хувь нийлүүлэх хөрөнгийн доод хэмжээг 200 сая төгрөг байхаар тогтоосон ба тайлант улирлын байдлаар ХААБ-уудын эздийн өмчийн хувь хэмжээ нийт пассивт харьцуулахад 89.5 хувь байна. Энэ нь үйл ажиллагааны эрсдэлийг өөрийн хөрөнгөөр хаах боломжтойг харуулж байна.

#### 2.4 Ашигт ажиллагаа, орлого зардлын байдал

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	Дүн
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>6,486,732,301</b>
2	Борлуулалтын өртөг	5,374,218,168
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>1,112,514,133</b>
4	Түрээсийн орлого	0
5	Хүүний орлого	1,252,526
6	Ногдол ашгийн орлого	0
7	Эрхийн шимтгэлийн орлого	22,276,796
8	Бусад орлого	650,000
9	Борлуулалт, маркетингийн зардал	286,426,454
10	Ерөнхий ба удирдлагын зардал	443,437,865
11	Санхүүгийн зардал	70,075,100
12	Бусад зардал	31,802,780
13	Бусад ашиг (алдагдал)	950,300
14	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>305,901,556</b>
15	Орлогын татварын зардал	34,498,469
16	Татварын дараах ашиг (алдагдал)	271,403,087
17	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0
18	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	271,403,087

ХААБ-уудын хувьд борлуулалтын орлого нь биржийн арилжааны зуулалын үйлчилгээний шимтгэл, хураамж байдаг. Хорооны 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 180 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйлчилгээний шимтгэл, хураамжийн хэмжээг хэлцлийн нийт үнийн дүнгийн 1.0 хувиас доошгүй байх”-аар тогтоосон. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны нээлт албан ёсоор 2013 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр эхлэн 2013 оны 6 дугаар сарын эцэс хүртэл ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос арилжаа явагдаж нийт 312.07 тэрбум төгрөгийн хэлцэл биелэсэн гэж биржээс мэдээлсэн.

Тайлангийн нэгтгэлд хамрагдсан 25 ХААБ-ын борлуулалтын орлого 6.48 тэрбум төгрөг буюу нийт биржийн арилжааны хэлцэлийн 2.07 хувийг эзэлж байна. Иймд ХААБ-уудын арилжааны үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээ хэлцлийн нийт үнийн дүнгийн дундажаар 2.0 орчим байна гэж үзэж болохоор байна. Гэвч зарим ХААБ-ууд харилцагчийг шудрага бусаар өөртөө татах үүднээс Хорооноос тогтоосон үйлчилгээний шимтгэл, хураамжийн доод хувь, хэмжээнээс доогуур хувь амлаж үйлчилгээ үзүүлсэн гэх мэдээлэл Хороонд ХААБ-уудаас ирсэн болно.

Иймд Хороонд ХААБ-уудад газар дээрх шалгалт хийх замаар үйлчилгээний шимтгэл, хураамжийн доод хувь, хэмжээг бууруулахгүйгээр тооцон авч байгаа эсэх мөн үүнийг санхүүгийн тайлан, орлогын тайланд үнэн зөв тусгаж байгаа эсэхийг тодруулах шаардлагатай байна.

**2.5 Алдагдалтай ажиллаж буй ХААБ-уудын мэдээлэл**

	ХААБ-ын нэр	Алдагдлын хэмжээ	Хувь
1	Ивээлт Инэл	(907,176.50)	2.3%
2	Бадархундага	(3,604,480.00)	9.2%
3	Изий плас	(50,000.00)	0.1%
4	Засагт хан гарьд	(8,807,100.00)	22.6%
5	Гүүд комэкс	(6,805,000.00)	17.4%
6	Саяанхаан	(7,365,072.00)	18.9%
7	Стандарт таваар	(11,494,697.00)	29.4%
	<b>Нийт</b>	<b>(39,033,525.50)</b>	<b>100.00%</b>

Дээрх 6 ХААБ-уудын хувьд биржийн арилжаанд оролцоогүй болон цөөн удаа оролцсон, борлуулалтын орлого бага буюу байхгүй үйл ажиллагааны зардал их гарган ажилласнаас алдагдал үүссэн байна.

**ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР**

Санхүүгийн зохицуулах хорооноос 2013 оны 3 дугаар сараас ХААБ-дад тусгай зөвшөөрөл олгож эхлэн Хорооны зохицуулалтанд Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлалын үйл ажиллагааг явуулдаг хуулийн этгээдүүдийг оруулсан. Одоогийн байдлаар Хорооноос 33 ХААБ зөвшөөрөл авсан ба Хорооны зүгээс 2013 оны 2 дугаар улирлаас эхлэн ХААБ-уудын санхүүгийн тайланг хүлээн авч нэгтгэх ажлыг хийж байна. Иймд тайлант улирлын хувьд ХААБ-уудын санхүүгийн тайлангийн өмнөх үеийн статистик мэдээлэл байхгүй, харьцуулсан үзүүлэлтүүд гарахгүй онцлогтой болно.

ХААБ-уудын хувьд шинэ тутам зохицуулалтанд орж буй тул санхүүгийн тайланг бүрэн гүйцэд, алдаагүй, хугацаанд гарган ирүүлж хэвшээгүй. Мөн дийлэнх ХААБ-дын удирдлага боловсон хүчин нь түүхий эд хувиараа бэлтгэн нийлүүлэх үйл ажиллагаа эрхэлж байсан ба санхүүгийн зуучлалын салбарт буюу Хөдөө аж ахуйн брокерын үйл ажиллагаа явуулахад зарим талаар санхүүгийн мэдлэг, дадал дутагдаж байгаа нь харагдаж байна.

Тухайлбал: Тайлан ирүүлбэл зохих 33 ХААБ-аас 25 нь тайланг ирүүлсэн, зарим ХААБ-ын балансын дүн зөрүүтэй, балансын тайлант үеийн ашиг/алдагдалын дүн, орлого үр дүнгийн тайлангийн ашиг/алдагдалын дүн зөрүүтэй, хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг тайланд тусгаагүй гэх мэт зөрчил, дутагдалуудтай байна.

**Активын бүтэц**

ХААБ-уудын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн активын үзүүлэлтээс харахад эргэлтийн хөрөнгө нийт активын 93.0 хувь, эргэлтийн бус хөрөнгө 3.9 хувийг тус тус эзэлж байна. Энэ харьцаа ХААБ нь санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа явуулдаг байгууллагын хувьд байвал зохих харьцаанд нийцсэн үзэж болохоор байна.

**Пассивын бүтэц**

Тайлант улиралд нэгтгэлд хамрагдсан ХААБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 4,522,690,731.00 төгрөг буюу нийт пассивын 82.9 хувийг эзэлж байна. Хорооны

зүгээс ХААБ-уудын мөнгөн хөрөнгөөр хувь нийлүүлэх хөрөнгийн доод хэмжээг 200 сая төгрөг байхаар тогтоосон ба тайлант улирлын байдлаар ХААБ-уудын эздийн өмчийн хувь хэмжээ нийт пассивт харьцуулахад 89.5 хувь байна. Энэ нь үйл ажиллагааны эрсдэлийг өөрийн хөрөнгөөр хаах боломжтойг харуулж байна.

***Алдагдалтай ажиллаж буй ХААБ-уудын мэдээлэл***

Дээрх 6 ХААБ-уудын хувьд биржийн арилжаанд оролцоогүй болон цөөн удаа оролцсон, борлуулалтын орлого бага буюу байхгүй үйл ажиллагааны зардал их гарган ажилласнаас алдагдал үүссэн байна.

***Цаашид авах арга хэмжээний талаар***

Хорооноос дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

Хорооноос нийт ХААБ-уудад зохицуулалтын хүрээний бодлогын баримт бичиг, аж ахуй нэгжийн нягтлан бодох бүртгэлийн талаар заавар, зөвөлгөө өгөх сургалтыг ойрын хугацаанд зохион байгуулах;

Түүнчлэн ХААБ-ны нягтлан бодох бүртгэлийн журам, заавар болон тайлангийн нэгдсэн маягтын загварыг боловсруулж Хорооны хурлаар батлуулах;

Хороонд ХААБ-уудад газар дээрх шалгалт хийх замаар үйлчилгээний шимтгэл, хураамжийн доод хувь, хэмжээг бууруулахгүйгээр тооцон авч байгаа эсэх мөн үүнийг санхүүгийн тайлан, орлогын тайланд үнэн зөв тусгаж байгаа эсэхийг тодруулах гэх мэт ажлыг зохион байгуулах нь зүйтэй.

**ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ СУДАЛГАА, САНХҮҮГИЙН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**